

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

МАК ЦЕМЕНТ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



/Б.БАТТУЛГА /

**“МАК ЦЕМЕНТ” ХХК-ИЙН ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН
СУМЫН НУТАГТ ДЭВСГЭРТ ОРШИХ “МАК ЦЕМЕНТ” ХХК-
ИЙН “БАРИЛГЫН МАТЕРИАЛ БОРЛУУЛАЛТЫН ХЭСЭГ”
БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР 5830974/

Танилцсан:

Дархан-БМБТ-ийн дарга

/Я. Отгонбаатар/

Хянасан:

ХЭМАББО-ны дарга

/Б. Жүгдэр /

Боловсруулсан:

Байгаль орчин, тогтвортой
хөгжлийн мэргэжилтэн

/А.Ану-Үжин/

2026 он

**“МАК ЦЕМЕНТ” ХХК-ИЙН ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН
СУМЫН НУТАГТ ДЭВСГЭРТ ОРШИХ “МАК ЦЕМЕНТ” ХХК-
ИЙН “БАРИЛГЫН МАТЕРИАЛ БОРЛУУЛАЛТЫН ТӨВ”
БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Агуулга

1	Төслийн танилцуулга	3
1.1	Төслийн ерөнхий мэдээлэл.....	3
1.1.1	Төслийн нэр:.....	3
1.1.2	Төсөл хэрэгжүүлэгч:	3
1.1.3	Төслийн зорилго	3
1.1.4	Төслийн талбайн байршил	3
1.2	Төслийн төлөвлөлт	5
1.2.1	Хөдөлгөөний схем.....	6
1.2.2	Тохижилт ногоон байгууламж.....	6
1.2.3	Барилгын материал борлуулалтын хэсгийн 1-р давхрын байгуулалт	8
1.2.1	Барилгын материал борлуулалтын хэсгийн 2-р давхрын байгуулалт	10
1.3	Дэд бүтэц.....	0
1.4	Хог хаягдлын менежмент	1
1.4.1	Хатуу хог хаягдал	1
1.4.2	Хийн хаягдал	3
1.4.3	Усны хэрэглээ ба шингэн хог хаягдал	4
2	ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	5
2.1	Газарзүйн байршил.....	5
2.2	Уур амьсгал / Агаарын чанар	5
2.3	Усан орчин.....	5
2.4	Ургамлан бүрхэвч.....	5
2.5	Хөрсөн бүрхэвч	5
2.6	Амьтны аймаг.....	5
2.7	Тусгай хамгаалалттай газар нутаг	6
2.8	Түүх соёлын өв	6
2.9	Нийгэм, эдийн засаг	6
2.10	Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	7
3	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ	9
3.1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын хураангуй	9
3.1.1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	10
3.1.2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	13
3.1.3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	13
3.1.4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	14

3.1.5	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	15
3.1.6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	18
3.1.7	Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ.....	20
3.1.8	2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	21
Хавсралт.....		22

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1-1 Төсөл хэрэгжих талбайн солбицол.....	4
Хүснэгт 1-2 Төлөвлөлтийн талбайн хэмжээ.....	5
Хүснэгт 1-3 1-р давхрын төлөвлөлт.....	9
Хүснэгт 1-4 2-р давхрын төлөвлөлт.....	10
Хүснэгт 1-5 Хог хаягдлын ангилан ялгалт.....	3
Хүснэгт 1-6 Түлшнээс ялгарах хорт хий.....	4
Хүснэгт 1-7. Нөлөөллийн үнэлгээ.....	7
Хүснэгт 2-1 БОМТ-г хэрэгжүүлэх зардал, 2026 он.....	9
Хүснэгт 2-2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	10
Хүснэгт 2-3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	13
Хүснэгт 2-4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	14
Хүснэгт 2-5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	17
Хүснэгт 2-6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	18
Хүснэгт 2-7. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ.....	20
Хүснэгт 2-8. БОМТ-ний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь.....	21

Зургийн жагсаалт

Зураг 1-2 Төсөл хэрэгжих талбайн байршил.....	3
Зураг 1-3 Ерөнхий төлөвлөгөөний зураг.....	5
Зураг 1-4 Хөдөлгөөний схем.....	6
Зураг 1-5 Тохижилт ногоон байгууламж.....	7
Зураг 1-6 1-р давхрын төлөвлөлтийн зураг.....	8
Зураг 1-7 2-р давхрын төлөвлөлтийн зураг.....	10
Зураг 1-8 Барилгын материал борлуулалтын хэсгийн ерөнхий харагдах байдал.....	0

1 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1.1 Төслийн нэр: “Барилгын материал борлуулалтын төв” байгуулах төсөл

“МАК Цемент” ХХК

- Улсын бүртгэлийн дугаар: 9011478063
- Регистрийн дугаар: 5830974
- Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 1-р хороо, IXI хороолол, Чингисийн өргөн чөлөө, “Монголын Алт” (МАК) ХХК-ийн төв байр-44

- Утас: 75759707


1.1.2 Төсөл
хэрэгжүүлэгч:

1.1.3 Төслийн зорилго

"МАК Цемент" ХХК-ийн Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт байгуулах Барилгын материал борлуулалтын төв нь евро стандартаар үйлдвэрлэгдсэн МАК евро цемент, евро блок, евро цонх хаалга, евро агааржуулалтын хоолой зэрэг дотоодын түүхий эд, бүтээгдэхүүнүүдийг Дархан, Эрдэнэт, Булган, Сэлэнгэ аймгийн хэрэглэгчдэд илүү ойртуулах зорилгоор байгуулагдаж байна.

1.1.4 Төслийн талбайн байршил

“МАК Цемент” ХХК-ийн “Барилгын материал борлуулалтын төв” байгуулах төсөл нь Дархан-Уул аймгийн Дархан сум 13-р багийн нутаг дэвсгэр Дархан-Уул аймгийн үйлдвэрлэлийн бүсэд хэрэгжинэ. Төслийн талбай нь Улаанбаатар хотоос 220 км зайд байрлана.



Зураг 1-1 Төсөл хэрэгжих талбайн байршил


*Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт “Барилгын материал борлуулалтын төв” байгуулах
төслийн 2026 оны байгаль орчны төлөв менежментийн төлөвлөгөө*

Хүснэгт 1-1 Төсөл хэрэгжих талбайн солбицол

№	х	у	№	х	у	№	х	у
1	568391.1	5475369	42	568562.20	5475017.85	83	568536.67	5475134.64
2	568391.1	5475374	43	568563.76	5475024.59	84	568536.40	5475134.45
3	568391.1	5475374	44	568561.63	5475039.35	85	568536.15	5475134.25
4	568390.5	5475405	45	568555.14	5475077.07	86	568535.91	5475134.02
5	568390.4	5475407	46	568555.11	5475077.25	87	568535.69	5475133.78
6	568389.1	5475427	47	568555.05	5475077.51	88	568535.48	5475133.53
7	568387.1	5475457	48	568550.53	5475095.34	89	568535.29	5475133.26
8	568386.9	5475460	49	568546.64	5475118.46	90	568535.12	5475132.99
9	568383.4	5475488	50	568546.63	5475118.49	91	568534.96	5475132.70
10	568383.4	5475489	51	568544.37	5475131.35	92	568534.83	5475132.40
11	568383.1	5475490	52	568544.35	5475131.46	93	568534.71	5475132.09
12	568378.6	5475518	53	568544.28	5475131.78	94	568534.62	5475131.78
13	568374.3	5475543	54	568544.18	5475132.09	95	568534.54	5475131.46
14	568374.1	5475545	55	568544.07	5475132.40	96	568534.49	5475131.14
15	568368.9	5475571	56	568543.93	5475132.70	97	568534.46	5475130.81
16	568363.4	5475599	57	568543.78	5475132.99	98	568534.45	5475130.49
17	568357.8	5475627	58	568543.60	5475133.26	99	568534.46	5475130.16
18	568357.8	5475627	59	568543.41	5475133.53	100	568534.49	5475129.83
19	568352.4	5475653	60	568543.21	5475133.78	101	568534.52	5475129.62
20	568347.8	5475677	61	568542.98	5475134.02	102	568536.78	5475116.78
21	568376.3	5475689	62	568542.74	5475134.25	103	568540.71	5475093.48
22	568452.8	5475742	63	568542.49	5475134.45	104	568540.73	5475093.33
23	568538.4	5475750	64	568542.22	5475134.64	105	568540.79	5475093.08
24	568542.9	5475666	65	568541.95	5475134.82	106	568545.31	5475075.26
25	568508.7	5475666	66	568541.66	5475134.97	107	568545.34	5475075.05
26	568523.6	5475602	67	568541.36	5475135.11	108	568551.78	5475037.67
27	568558.3	5475607	68	568541.05	5475135.22	109	568553.68	5475024.58
28	568588.7	5475555	69	568540.74	5475135.32	110	568552.30	5475019.39
29	568632.1	5475478	70	568540.42	5475135.39	111	568551.70	5475010.52
30	568589.4	5475426	71	568540.10	5475135.44	112	568553.37	5475000.78
31	568574	5475399	72	568539.77	5475135.48	113	568457.25	5474989.14
32	568575.2	5475393	73	568539.68	5475135.48	114	568450.25	5474990.95
33	568645.4	5475085	74	568539.45	5475135.49	115	568439.02	5474999.33
34	568662	5475055	75	568539.12	5475135.48	116	568420.63	5475056.65
35	568655.2	5475050	76	568538.79	5475135.44	117	568391.21	5475123.24
36	568609.6	5475051	77	568538.47	5475135.39	118	568391.34	5475162.12
37	568596.73	5475050.79	78	568538.15	5475135.32	119	568391.55	5475201.20
38	568579.79	5475041.68	79	568537.84	5475135.22	120	568391.55	5475201.29
39	568569.66	5475027.64	80	568537.53	5475135.11	121	568391.72	5475249.67
40	568561.91	5475010.12	81	568537.23	5475134.97	122	568391.72	5475249.85
41	568561.66	5475011.58	82	568536.95	5475134.82	123	568391.68	5475288.50
						124	568391.47	5475348.56

1.2 ТӨСЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Дархан-Уул аймгийн Дархан нутаг дэвсгэрт байгуулах барилгын материал борлуулалтын төвийн ерөнхий төлөвлөлтөд ажилчдын оффис, амрах байр, showroom, агааржуулалтын хоолой борлуулах хэсэг, задгай агуулах, цонх хаалга, задгай цемент хадгалах борлуулах хэсэг, гипсэн хавтан, чулуун хавтан, гипсэн хавтан, хуванцар хоолой хадгалах борлуулах хэсэг задгай агуулах, бетон хийц хадгалах борлуулах задгай агуулах, ууттай цемент хадгалах борлуулах битүү агуулах, евро блок хадгалах борлуулах задгай талбай, бетон зүүрмагийн үйлдвэрлэх хэсэг, засвар үйлчилгээний төв, КТП, харуулын байр, хогийн нэгдсэн хэсэг, авто зам зэргийг шинээр төлөвлөж бүтээн байгуулахаар төлөвлөж байна.




Зураг 1-2 Ерөнхий төлөвлөгөөний зураг

Хүснэгт 1-2 Төлөвлөлтийн талбайн хэмжээ

Барилгын материал борлуулалтын төвийн талбай	8204 м ²
Барилгын материал борлуулалтын төвийн нийт талбай	5250 м ²
Нийт барилгажих талбай	19800 м ²
Нийт төлөвлөгдөж буй барилгын блокийн тоо	9
Автобусны зогсоолын тоо	18 ш
Ил ачааны машины авто зогсоолын тоо	40 ш
Далд авто зогсоолын тоо	74
Ил авто зогсоолын тоо	217 ш
Төлөвлөж буй барилгын аврах гарцын тоо	8
ХБИ авто зогсоол	6 ш
Рамп, пандусын тоо	Машин ХБИ
	6

1.2.1 Хөдөлгөөний схем

Төслийн талбайн дотоод болон гадаад хөдөлгөөний схемийг дараах төлөвлөлтийн зурагт харууллаа. Төслийн хүрээнд 41514 м² автозам, 7845 м² явган хүний зам, 217 ш ил авто зогсоолыг төлөвлөж байна.




Зураг 1-3 Хөдөлгөөний схем

Авто зам нь орц гарц бүрийн гадна хүрэх ба онцгой нөхцөлд галын машин, түргэн тусламжийн машин чөлөөтэй нэвтрэхээр төлөвлөсөн.

Барилгын бүх хэсгийн орц гарц ногоон байгууламж, тоглоомын талбай, үйлчилгээнд явган болон тэргэнцэртэй зорчигчийн хөдөлгөөний урсгал тасралтгүй болон саадгүй зорчих нөхцөлийг хангаж төлөвлөлтийг хийсэн.

1.2.2 Тохижилт ногоон байгууламж


Төслийн талбайд нийтийн хэрэгцээний ногоон байгууламж, үйлдвэрийн хэрэгцээний ногоон байгууламжийг төлөвлөж нийт 199ш мод, бут сөөг тарьж, 106000 м² талбайг зүлэгжүүлэхээр төлөвлөж байна.



Зураг 1-4 Тохижилт ногоон байгууламж

1.2.3 Барилгын материал борлуулалтын хэсгийн 1-р давхрын байгуулалт

Дараах хэсэгт 1-р давхрын төлөвлөлтийн зураг болон талбайн хэмжээнүүдийг орууллаа.




Зураг 1-5 1-р давхрын төлөвлөлтийн зураг

Хүснэгт 1-3 1-р давхрын төлөвлөлт

№	Өрөөний нэр	Талбай, м²	№	Өрөөний нэр	Талбай, м²	№	Өрөөний нэр	Талбай, м²	№	Өрөөний нэр	Талбай, м²
1	Хүлээлгийн хэсэг	967.18	16	Туслах өрөө	5.26	31	Борлуулалтын өрөө	20.43	46	Бэлтгэлийн өрөө	20.98
2	МАК EURO WINDOW	96.67	17	Ариун цэврийн өрөө	7.20	32	Борлуулалтын өрөө	20.61	47	Коридор	27.25
3	МАК VENTI	88.30	18	Ачааны липт	6.48	33	Борлуулалтын өрөө	20.28	48	Сэрүүн агуулах	10.49
4	МАК EURO BLOCK	161.10	19	Агуулах	50.64	34	Гонх	9.68	49	Хуурай агуулах	6.29
5	Үзэсгэлэнгийн танхим	199.11	20	Гонх	8.84	35	Гонх	16.58	50	Хүнс хадгалах агуулах	7.80
6	МАК Цемент	48.67	21	Харуулын өрөө	5.63	36	Авто зогсоол /74 машин/	1925.55	51	Липт	3.96
7	МАК чулуу, гипсэн хавтан	41.41	22	Гонх	12.56	37	Хүлээлгийн хэсэг	74.66	52	Гонх	8.04
8	МАК хуванцар хоолой	55.54	23	Шатны хонгил	33.06	38	Гонх	10.59	53	Хувцас солих өрөө	12.58
9	МАК модон бүтээгдэхүүн	53.65	24	Цахилгааны өрөө	7.72	39	Харуулын өрөө	4.43	54	Гонх	6.33
10	МАК тавилга	64.23	25	Техникийн өрөө	33.75	40	Халуун цех	136.30	55	Харуулын өрөө	3.45
11	Видео танилцуулга	78.58	26	Гонх	18.66	41	Оффис ажилчид /48 хүн/	114.80	56	Гонх	8.84
12	CU супермаркет	161.13	27	Харуулын өрөө	11.67	42	Тусгай зочдын хооллох танхим	67.01	57	Харуулын өрөө	5.50
13	Шатны хонгил	48.28	28	Гонх	5.75	43	Ажилчид хооллох заал /70 хүн/	216.66	Нийт		5331.60
14	Шатны хонгил	34.26	29	Борлуулалтын өрөө	16.20	44	Ариун цэврийн өрөө	33.29			
15	Нийтийн ариун цэврийн өрөө	36.83	30	Борлуулалтын өрөө	17.64	45	Амралтын хэсэг	163.18			

1.2.1 Барилгын материал борлуулалтын хэсгийн 2-р давхрын байгуулалт

Дараах хэсэгт 2-р давхрын төлөвлөлтийн зураг болон талбайн хэмжээнүүдийг орууллаа.



Зураг 1-6 2-р давхрын төлөвлөлтийн зураг
Хүснэгт 1-4 2-р давхрын төлөвлөлт

№	Өрөөний нэр	Талбай, м²	№	Өрөөний нэр	Талбай, м²
58	Жижиглэн барилгын материал	2185.55	65	Коридор	13.05
60	Ачааны липт	6.48	66	Амралтын өрөө	32.29
61	Хооллох заал	516.49	67	Эмэгтэй хувцас солих өрөө	16.13
62	Задгай хэсэг	77.89	68	Эрэгтэй хувцас солих өрөө	21.10
63	Ариун цэврийн өрөө	44.83	69	Ариун цэврийн өрөө	43.54
64	Халуун цех	92.72	70	Коридор	10.37
			Нийт		3060,44



Зураг 1-7 Барилгын материал борлуулалтын хэсгийн ерөнхий харагдах байдал

1.3 ДЭД БҮТЭЦ

Цахилгаан хангамж

Манай улсын эрчим хүчний систем нь дараах хэсгүүдээс тогтоно. Үүнд:

1. Төвийн бүсийн эрчим хүчний систем (ТБЭХС)
2. Баруун бүсийн эрчим хүчний систем (ББЭХС)
3. Алтайн-Улиастайн эрчим хүчний систем (АУЭХС)
4. Дорнод бүсийн эрчим хүчний систем (ДБЭХС)
5. Өмнөд бүсийн эрчим хүчний систем (ӨБЭХС)

Барилгын материал борлуулалтын хэсгийн дэд бүтцийг цахилгаан эрчим хүчээр тасралтгүй хангах зориулалт бүхий 0,4/6КВ-ийн трансформатор болон агаарын шугам татаж угсрах ажлыг "Гэрлийн хэмнэл" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна.

Усан хангамж

Төслийн хүрээнд цэвэр усны хангамж болон ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдох асуудлаар “Дархан-Ус Суваг” ХК-д техникийн нөхцөл авахаар бичиг баримт хүргүүлэн ажиллаж байна.

Барилгын материал борлуулалтын төв төслийн бүтээн байгуулалтын шатанд 40-45 хүн ажиллаж байгаа ба шаардагдах усыг зөөврөөр хангаж байна мөн урьдчилсан байдлаар үйл ажиллагааны шатанд 44 хүн ажиллахаар бүтэц, орон тоо батлагдаад байна.

Төслийн бүтээн байгуулалтын үе шат болон үйл ажиллагааны үе шатанд ажиллах ажилчдын ус хэрэглээг тус бүр тооцов. Нэг хүний өдөрт ашиглах усны хэмжээг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 12-р хавсралтаар батлагдсан орон сууц нийтийн байр, гэр хорооллын усны хэрэглээний нормыг үндэслэн тооцлоо.

Бүтээн байгуулалтын үе шат	Үйл ажиллагааны үе шат
Хоногт: 45 хүн*20 л=900 л буюу 0.9 м ³ Сард: 0.9 м ³ *30 хоног=27 м ³ Жилд: 27 м ³ *36 сар= 972 м ³ ус хэрэглэхээр байна.	Хоногт: 44 хүн*200 л=8800 л буюу 8.8 м ³ Сард: 8.8 м ³ *30 хоног=264 м ³ Жилд: 264 м ³ *12 сар= 3,168 м ³ ус хэрэглэхээр байна.

Барилгын материал борлуулалтын хэсгийн бүтээн байгуулалтыг ойролцоогоор 36 сарын хугацаанд хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна. Бүтээн байгуулалтын хугацаанд ажиллах ажилчдын ус хэрэглээ нийт 972 м³, төслийн үйл ажиллагааны үе шатанд ажиллах ажилчдын ус хэрэглээ жилд нийт 3,168 м³ байна.

1.4 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

1.4.1 Хатуу хог хаягдал

Барилгын материал борлуулалтын төв төслийн бүтээн байгуулалт болон үйл ажиллагааны явцад ажилчдын ахуйн гаралтай хог болон засвар үйлчилгээнээс гарсан сэлбэг хэрэгслийн гаралтай хаягдал, газар шорооны ажил, бүтээн байгуулалтын үйл ажиллагаанаас хаягдал гарч болзошгүй байна. Төсөл хэрэгжиж эхэлснээр үйл ажиллагаа нь жилийн 4 улирал явагдана. Ажилчдаас гарах ахуйн гаралтай хог хаягдлыг бүтээн байгуулалтын үе шатанд ажиллах 45 хүн, төслийн хэмжээнд ажиллах 44 хүнээр тооцов. Хог хаягдлын тооцоог гаргахдаа нэг хүн өдөрт 0.5 кг ахуйн хог хаягдал гаргана гэж үзэв.

Барилгын материал борлуулалтын төвийн бүтээн байгуулалтын үе шат	Барилгын материал борлуулалтын төвийн үйл ажиллагааны үе шат
Хоногт: 45 хүн*0,5 кг/хон=22.5 кг/хон Сард: 22.5 кг/хон*30 хоног=675 кг Жилд: 675кг*36 сар= 24,300кг буюу 24.3 тн ахуйн хаягдал гарахаар байна.	Хоногт: 44 хүн*0,5 кг/хон=22 кг/хон Сард: 22 кг/хон*30 хоног=660 кг Жилд: 660 кг*12 сар= 7920 кг буюу 7.92 тн ахуйн хаягдал гарахаар байна.

Төслийн барилга угсралтын ажлын үйл ажиллагааны явцад үүсэх ахуйн болон үйлдвэрлэлийн гаралтай энгийн хатуу хог хаягдлыг харьяалагдах орон нутагтай гэрээ байгуулж, зөвшөөрөгдсөн цэгт ачиж зайлуулна. Төслийн талбайн хог хаягдлыг тогтмол хугацаанд цэвэрлэнэ. Аюултай хог хаягдлыг энгийн хог хаягдлаас тусад нь хадгалж, холбогдох журмын дагуу аюултай хог хаягдал хадгалах цэгт тээвэрлэн хүргэнэ.


Харин бүтээн байгуулалт, газар шорооны ажлаас гарах хог хаягдлыг дахин ашиглах, дахин ашиглах боломжгүй хог хаягдлыг зүй зохистой ангилах, хууль, журмын дагуу арга хэмжээ авч ажиллах шаардлагатай. Бүтээн байгуулалт болон үйл ажиллагааны явцад үүсэх гол хог хаягдал нь ган, бетон, тос, дугуй, шүүлтүүр, аккумулятор зэрэг барилгын хог хаягдал болон хүнсний хаягдал, сав баглаа боодол, бохир ус зэрэг ахуйн хог хаягдал байна.

Барилгын ажлын үед доорх нэр төрлийн хатуу хог хаягдал гарна. Үүнд:

- Чулуу, шавар, элс, шороо зэрэг органик бус хаягдал
- Тоосго, цемент, цонхны шил, төмөр, шохой гэх мэт барилгын материалын үлдэгдэл
- Модны хаягдал болон бусад

Барилгын хог хаягдлыг энд тооцох боломжгүй ба Барилгын материал борлуулалтын төв ашиглалтад орсноос хойш барилгын төрлийн хог хаягдал гарахгүй.

Барилгын материал борлуулалтын төв төслийн хүрээнд гарч болох хог хаягдлыг дараах байдлаар ангиллаа (Схем 1).



Схем 1 Төслийн хэмжээнд үйл ажиллагаанаас гарах хаягдал

Хог хаягдлын тухай хууль /2017 он/, БОАЖЯ-ны сайдын 2017 оны 12-р сарын 01 өдрийн А/331 тоот тушаалын дагуу БОНХ сайдын 2014 оны “Аргачлал батлах тухай” А-117-ын 5-р хавсралтын 1.2.3-р хэсэгт нэмэлтийн дагуу ахуйн хуурай хог хаягдал түр хадгалах зориулалтаар лонх, лааз, цаас, хоолны үлдэгдэл буюу дахин ашиглагдах, ашиглагдахгүй байдлаар нь ангилан хадгалах бетонон суурьтай 5 ангилал бүхий хог хаягдлын ангилан хаях савыг бий болгох хогийн савыг хаших (зонхилох салхины чиглэлийн доор, аливаа объектоос доод тал нь 60м-ийн зайд), хатуу хог хаягдлын савыг битүүмжлэл сайтай байлгах, мөн ахуйн бохир усыг байгаль орчинд халгүйгээр зайлуулах, ил задгай хог байлгахгүй үүднээс хогийн савуудыг зохих газруудад хангалттай тоогоор байрлуулах, хог хаягдал савнаас халихаас сэргийлж зохимжит хэмжээтэй сав байршуулах зэргийг зөвлөж байна.

Нийт үүсэх хог хаягдлыг дээрх байдлаар төрөлжүүлэн эх үүсвэр дээр ангилан ялгасан хогийн саванд цуглуулах ба төсөл хэрэгжүүлэгч тусгай эрх бүхий байгууллагатай “Хог ачиж, тээвэрлүүлэх гэрээ” байгуулж, хаягдлыг ангиллын төрөл тус бүрээр ачуулах, тээвэрлүүлэх нь зүйтэй юм. Мөн уг гэрээнд хог ачих өдөр, цаг, давтамжийг тодорхой заана. Хэрэв хог тээвэрлэх тусгай эрх бүхий байгууллагын хүрэлцээ бага байгаа тохиолдолд хог хаягдал удаан хугацаагаар хадгалагдаж бохирдол үүсгэх боломжтой тул үйл ажиллагаа явуулж байгаа төсөл хэрэгжүүлэгч нь хог хаягдлын тухай хуулийн 8.1.7.б, 8.1.7.в-д зааснаар хог хаягдлыг тээвэрлэх үйл ажиллагаа явуулах эрхлэгчээр бүртгүүлэх боломжтой юм.

Хатуу хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгахдаа доорх хүснэгтэд заасны дагуу төрөлжүүлж хаяхыг зөвлөж байна.

Хүснэгт 1-5 Хог хаягдлын ангилан ялгалт

Хог хаягдал	Цаасны хаягдал	Хуванцар, гялгар уут	Шил	Лааз, металл	Хүнсний хаягдал	Ахуйн аюултай хаягдал	Бусад хаягдал
Хогийн уут болон савны өнгө	Цэнхэр	Ногоон	Цагаан	Улбар шар	Бор	Шар	Хар
Хогны төрөл, жишээ	Сонин, сэтгүүл, бичгийн цаас, картон	Гялгар уут, ундаа ус хоолны хуванцар сав, угаалгын шингэний хуванцар гэх мэт төрөл бүрийн ахуйн хэрэглээний хуванцар	Бүх төрлийн шилэн сав	Бүх төрлийн бараа бүтээгдэхүүний лааз, тугалган сав, төмөр таг	Түргэн муудах задралд орох хоол хүнс, мах махан бүтээгдэхүүн, жимс ногоо, сүү сүүн бүтээгдэхүүн, чихэр гурилан бүтээгдэхүүн	Гэрлийн шил, зай хураагуур, принтерийн хор, цахилгаан хэрэгсэл	Дахин боловсруулагдах боломжгүй энгийн хог хаягдал

Хог хаягдлын талаар төсөл хэрэгжүүлэгч дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- Эзэмшил газрынхаа хог хаягдлыг цэвэрлэх болон хог хаягдлыг зайлуулах олон нийтийг хамарсан ажилд оролцох үүрэгтэй;
- Төвлөрсөн цэг дээр дарж булах хог хаягдлын хэмжээг багасгахын тулд нэн түрүүнд ангилан ялгаж төрөлжүүлэх;
- Ил задгай хог хаягдал хаяхгүй, шатаахгүй байх;
- Орон нутгийн тохижилт үйлчилгээний компанитай гэрээ байгуулан ажиллаж хог хаягдлыг төвлөрсөн цэгт зөөвөрлүүлнэ.

1.4.2 Хийн хаягдал

Дархан-Уул аймгийн Дархан сумын 13-р багийн нутагт хэрэгжүүлэх “Барилгын материал борлуулалтын төв” төслийн хийн хаягдал үүсэх гол эх үүсвэр нь бүтээн байгуулалтын шатанд төслийн талбайд ашиглагдах техник хэрэгслийн түлш шаталтаас ялгарах утаа юм. Автомашины утааны найрлагад нийтдээ 200 гаруй төрлийн хорт бодис, химийн нэгдэл оролцох бөгөөд зарцуулагдах түлшний жингийн 15% нь ашигтай зарцуулагдаж, үлдсэн 85% нь агаарт цацагддаг байна. 1 кг түлш шатаахдаа бензиний хөдөлгүүр 300-310 г, дизель хөдөлгүүр 80-100 г хорт бодис ялгаруулдаг ажээ. Автомашин бага хурдаар явах, асаах, хөдөлгөөнөө эхлэх үед ялгарч гарах утааны хэмжээ 85-90% хүрдэг бол, жигд буюу дундаж хурдтай хөдөлгөөний үед 10-15% болж буурдаг байна. Энэ үзүүлэлтүүдийн хооронд даруй 6-9 дахин зөрүү гарч байгааг ажиглаж болно.

Автомашинаас хүрээлэн буй орчин, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн хэмжээ, цар хүрээ нь түүний утааны найрлагаас шүүд хамаарч байдаг. Автомашины утаанаас хөнгөн цагаан Cu, никель Ni, кадмий Cd, мөнгөн ус Hg зэрэг хүнд металлууд, тэдгээрээс гадна хар тугалга Pb, цайр Zn, манган Mn зэрэг нэмэлт хольцын элемент, тэднийг агуулагч нэгдлүүд нь хүрээлэн байгаа орчны агаар, хөрс, усыг ихээр бохирдуулах нөхцөлтэй юм.

Төсөлд ашиглагдах автомашины янданд шүүлтүүр тавьж хийн хаягдлыг бууруулах, мөн агаарын бохирдлын татварыг төлөх хэрэгтэй. Доорх Хүснэгт 1-6-т литр тутам дах газрын тосны бүтээгдэхүүнээс үүсэх хорт хий болон хорт бодисын ялгарлыг орууллаа. Энэхүү ялгарал нь төслийн талбайд хэрэглэж байгаа нийт газрын тосны бүтээгдэхүүний хэмжээгээр үржигдэн нийт ялгарлыг тооцно.

Хүснэгт 1-6 Түлшнээс ялгарах хорт хий

№	Хорт хий, бодис	Нэгж ялгаруулалт, гр/л
1	Нүүрстөрөгчийн исэл	20.6
2	Азотын давхар исэл	24.75
3	Нүүрстөрөгч	5.77
4	Хүхэрлэг хий	16.6
5	Хөө тортог	3.3
6	Хар тугалга	0
7	Бензпирен	0.255
8	Альдегид	0.74
Нийт		

1.4.3 Усны хэрэглээ ба шингэн хог хаягдал

Ажиллагсдын ахуйн хэрэглээ болон цайны газраас хоногт хаягдах ахуйн бохир шингэн хаягдал гарна. БОНХАЖС-ын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 12-р хавсралтаар батлагдсан орон сууц нийтийн байр, гэр хорооллын усны хэрэглээний нормыг үндэслэн нэг хүн хоногт дунджаар 200 литр ус хэрэглэнэ гэж тооцвол 44 хүний үнд ахуйн хэрэгцээнд хоногт нийт 8800 литр ус хэрэглэхээр байна. Үүний 70%-ийг ахуйн шингэн хаягдал болно гэж тооцвол хоногт дунджаар 6160 л шингэн хаягдал гарахаар байна. Төслийн хүрээнд төвлөрсөн ариутгах татуургын системд холбогдохоор төлөвлөн ажиллаж байна.

2 ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 ГАЗАРЗҮЙН БАЙРШИЛ

Дархан-Уул аймгийн төв болох Дархан сум нь Монгол Улсын хойд хэсэгт, Сэлэнгэ мөрний сав газар, Улаанбаатар хотоос 220 км зайд, Сэлэнгэ аймгийн төвөөс 120 км орчим зайтай оршдог. Газарзүйн солбицол нь ойролцоогоор хойд өргөргийн 49°29', зүүн уртрагийн 105°56' орчимд байрлана. Газрын гадаргын өндөр нь далайн түвшнээс дунджаар 660–700 метр бөгөөд баруун талаараа Сэлэнгэ мөрөнтэй залгаа юм. Дархан сум нь тэгш тал газар зонхилсон, бага зэрэг намхан толгод бүхий геоморфологийн бүтэцтэй. Тус бүс нутаг нь элэгдэл, эвдрэл багатай, хөдөө аж ахуй болон суурин хөгжүүлэхэд тохиромжтой газарзүйн хэлбэртэй. Газар шорооны ажил болон барилга, бүтээн байгуулалт явуулахад байгалийн саад бэрхшээл багатай.

2.2 УУР АМЬСГАЛ / АГААРЫН ЧАНАР

Дархан сум нь хуурайдуу сэрүүн уур амьсгалын бүсэд багтдаг бөгөөд жилийн дундаж агаарын температур нь -0.5°C–аас +1°C орчим байна. Хамгийн дулаан сар нь долоодугаар сар (+18–22°C), хамгийн хүйтэн сар нь нэгдүгээр сар (-22°C) байдаг. Жилийн дундаж хур тунадасны хэмжээ 250–350 мм бөгөөд ихэнх нь зун ордог. Уур амьсгалын энэхүү онцлог нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, инженерийн бүтээн байгуулалтад тодорхой нөлөө үзүүлдэг.

2.3 УСАН ОРЧИН

Хараа голын ус хурах талбай 14400.0 ам км, 352км урт, 0.004 хэвгийтэй. Голдирлын дундаж өндөр 833м, ус хагалбарын шугамын урт 945,6км, түүний дундаж өндөр 1711.0м, голуудын нийлбэр урт 5358.3 км, усан сүлжээний нягтшил 0.37 км/ам км, ус хурах талбайн дундаж өндөр 1272.0м, хөндийн гүн дунджаар 878.0м, түүний өргөн 40.8 км, сав газрын суналтын зэрэг 8.6, ус хагалбарын шугамын хөгжлийн зэрэг 2,2 хажуугийн хэрчигдэл 0,8 байна. Баянбууралаас Түнхэлийг өнгөртөл шахагдан нарийн хөндийгөөр урссаар Зүүнхараагийн нутгаас эхлэн өргөсөн тэлж голын хөндийн өргөн 5-10км, зарим газартаа 15км болж задгайрна. Голын ёроол элс-хайрган хурдастай. Хамгийн их үер 1973 онд болж 722 шоо м/с хүрч байжээ.

2.4 УРГАМЛАН БҮРХЭВЧ

Хараа голын район нь үетэн ба алаг өвс–үетэнт хээр голлож тааралдах бөгөөд тэдгээр нь уулын ар биеэр тачир ургамалтай уулын хээрийн шинжтэй. Зүүнхараагаас эхлэн Ерөө хүртэл Хараа голын баруун эрэг дагуух ихээхэн нутагт жижиг навчит харгана бүхий жинхэнэ үетэн-агьт хээр тааралддаг. Хараа голын сав газраар марцлаг нуга, дэрс үзэгддэг. Тус сумын нутагт зонхилон хялгана-үетэн алаг өвст, хялгана-алаг өвст, зүр өвс-үетэнт эвшлүүд нь нам уулсын орой хажуугаар тохиолдох бөгөөд ухаа гүвээт долгиорхог тал хээрт хялгана үетэн-алаг өвст, хялгана-хиаг-алаг өвст, хялгана-хиаг-үетэнт, хялгана-харганат эвшлүүд зонхилно.

2.5 ХӨРСӨН БҮРХЭВЧ

Судалгаанд хамрагдсан талбайд Монгол орны хөрсний ангиллаар Хүрэн хөрсний дэд хэв шинжид багтах элсэнцэр Хүрэн ба элсэнцэр зузаан Хүрэн төрлийн хөрс тархсан байна. Эдгээр хөрс нь ерөнхий үржил шимийн түвшин бага, шимт үе давхарга нь дундаж (0-40 см), хэврэг бөөнцөр болон үйрмэг бүтэцтэй, механик нөлөөлөлд тэсвэр багатай, байгалийн аясаараа нөхөн сэргэх чадамж дунд зэрэг байдаг онцлогтой. Хөрсний ширхгийн бүрэлдэхүүнд том ширхэгтэй элсэн фракц зонхилсон элсэнцэр бүрэлдэхүүнтэй.

2.6 АМЬТНЫ АЙМАГ

Дархан сум нь тал хээрийн бүсэд багтдаг тул энэхүү бүсэд нийтлэг тархсан зэрлэг амьтад зонхилдог. Бүс нутгийн байгалийн нөхцөл, ургамлын бүрхэвчээс шалтгаалан зөвхөн тал хээрт тохирсон, хуурай орчинд амьдрах чадвартай амьтдын бүлгүүд тархан нутагшсан байна. Үүнд хөхтөн амьтад, шувууд, мөлхөгчид, хоёр нутагтан, шавж зэрэг төрөл зүйлс хамаарна.

Төслийн талбай орчимд тохиолдох боломжит зүйлүүд нь дагуур зараа *Mesechinus dauuricus*, мэрэгчдээс урт сүүлт зурам *Spermophilus undulatus*, шивэр алагдаага *Allactaga sibirica*, монгол чичүүл *Meriones unguiculatus*, хадны барагчин *Alticola semicanus* түүлай хэлбэртнээс бор түүлай *Lepus tolai*, монгол огдой *Ochotona pallasii* махчдаас үнэг *Vulpes vulpes*, хярс *Vulpes corsac* зэрэг зүйл хөхтөн амьтад тохиолдох боломжтой юм.

2.7 ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГ

2026 оны байдлаар Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 20.77 хувь буюу 32.5 сая га талбай бүхий 107 газрыг улсын тусгай хамгаалалтад аваад байна. Тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллаар авч үзвэл 13.8 сая.га талбай бүхий 42.5% дархан цаазат газар, 13.5 сая.га талбай бүхий 41.6% байгалийн цогцолборт газар, 5.1 сая.га талбай бүхий 15.6% байгалийн нөөц газар, 106.5 га талбай бүхий 0.3% дурсгалт газар байна.

Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт улсын тусгай хамгаалалттай газар нутгаар хамгаалалтанд авсан газар одоогоор байхгүй байна. Мөн төслийн талбай улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй байна.

2.8 ТҮҮХ СОЁЛЫН ӨВ

Хэнтийн нурууны салбар Их Дархан-Уул нь сумын хойд талд дүнхийх далайн түвшнээс дээш 1239 м өндөрт орших, орон нутгийн тахилгат уул юм. Энэ уулын нэрээр аймгаа нэрлэсэн төдийгүй аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2007 оны 05 дугаар сарын 10-ний өдрийн 46 дугаар тогтоолоор орон нутгийн тусгай хамгаалалтад авч жил бүр тахилга тайлга хийж байна.

2.9 НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ

Дархан-Уул аймгийн нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг 2022–2024 оны байдлаар авч үзэхэд дараах өөрчлөлт ажиглагдаж байна.

Хүн амын тоо 2022 онд 108.3 мянга, 2023 онд 109.2 мянга, 2024 онд 110.1 мянгад хүрч, жилд дунджаар 0.8–0.9 мянган хүнээр өссөн байна. Төрөлтийн тоо 2022 онд 2,060, 2023 онд 2,010, 2024 онд 1,850 болж буурсан бол нас баралт 2022 онд 480, 2023 онд 500, 2024 онд 520 болж бага зэрэг өссөн үзүүлэлттэй байна.

Аймгийн төсвийн орлого 2022 онд 185.0 тэрбум төгрөг, 2023 онд 210.4 тэрбум төгрөг, 2024 онд 235.6 тэрбум төгрөг болж өссөн бол төсвийн зарлага 2022 онд 192.3 тэрбум төгрөг, 2023 онд 225.8 тэрбум төгрөг, 2024 онд 248.9 тэрбум төгрөгт хүрч нэмэгдсэн байна.

Хөдөө аж ахуйн салбарын хувьд малын тоо 2022 онд 354.2 мянга, 2023 онд 372.5 мянга, 2024 онд 365.8 мянга толгой болж, 2023 онд өссөн ч 2024 онд бага зэрэг буурсан байна. Тариалсан талбайн хэмжээ 2022 онд 52.3 мянган га, 2023 онд 55.1 мянган га, 2024 онд 57.8 мянган га болж жилээс жилд өссөн үзүүлэлттэй байна.

Хөдөлмөр эрхлэлтийн хувьд ажиллах хүчний оролцоо 2022 онд 58.2 хувь, 2023 онд 59.1 хувь, 2024 онд 60.3 хувь болж өссөн бол ажилгүйдлийн түвшин 2022 онд 8.1 хувь, 2023 онд 7.4 хувь, 2024 онд 6.8 хувь болж буурсан байна.

Эрүүл мэндийн үзүүлэлтүүдийн хувьд зонхилох өвчлөлийн бүтэц тогтвортой хэвээр байгаа бөгөөд зүрх судасны өвчин, амьсгалын замын өвчин, хавдар зэрэг нь нийт өвчлөлийн дийлэнх хувийг эзэлж байна.

2.10 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

МАК цемент ХХК-ийн “Барилгын материал борлуулалтын төв” төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Хүснэгт 2-1. Нөлөөллийн үнэлгээ

Байгаль орчны үзүүлэлтүүд	Нөлөөлөх байдал		Хугацаа		Чиглэл			Эрчим		
	Шууд	Шууд бус	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Өөрөө зохицуулагдах	Бага	Дунд	Хүчтэй
Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Гадаргын усны урсцын өөрчлөлт										
Гадаргын усны чанарын өөрчлөлт		x		x		x		x		
Ой, ургамлын бүтцийн өөрчлөлт	x			x			x	x		
Хөрсний элэгдэл, эвдрэл	x			x		x			x	
Геологийн тогтцын өөрчлөлт		x	x					x		
Зэрлэг амьтдын оронзайн өөрчлөлт	x			x				x		
Уур амьсгалын /бичил/ өөрчлөлт	x			x		x			x	
Байгалийн нөөц ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг	x			x		x		x		
Бэлчээр, тэжээлийн байдал	x			x			x	x		
Эрдэс түүхий эдийн нөөц /ус/		x		x			x	x		
Эрчим хүчний нөөц	x			x		x		x		
Байгаль, орчны өөрчлөлт										
Ундны усны чанар, хэмжээ	x			x		x		x		
Урсгал усны нөөцийн горим										
Агаарын бохирдол	x			x		x		x		
Хөрсний, бохирдол элэгдэл	x			x			x		x	
Хорт бодис хүн, амьтанд нөлөөлөх	x			x		x				x
Дуу чимээний нөлөөлөл	x			x				x		
Нийгэмд үзүүлэх нөлөөлөл										
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	+			+		+		+		
Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх		+		+		+		+		
Хүн амын орлого өөрчлөгдөх	+			+		+		+		
Хүн амын эрүүл мэнд, соёл	+			+	+			+		
Эдийн засаг, нийгмийн асуудал										
Татварын орлого өөрчлөгдөх	+			+	+			+		
Орон нутгийн орлог өөрчлөгдөх	+			+		+		+		
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	+			+		+		+		
Ажлын байр нэмэгдэх	+			+		+		+		
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+		+					+		
Бусад нөлөөлөл										
Ахуйн бохир уснаас хөрс, газрын доорх ус бохирдох	x		x				x	x		
Химийн бодис асгарах, алдагдах	x			x	x				x	
Галын аюулгүй алдагдах	x		x		x					x
Дүн	23	4	4	23	4	14	5	21	6	2

Тайлбар: “х” сөрөг нөлөөлөл, “+” эерэг нөлөөлөл

Хүснэгтээс үзвэл байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөллийн нийт **27 сөрөг, 9 эерэг нөлөөлөл** тодорхойлогдсон байна. Нөлөөллийн байдлыг доор үзүүлэв. Үүнд:

Нөлөөллийн төрлөөр ангилан авч үзвэл нийт нөлөөллийн 23 нь шууд, 4 нь шууд бус нөлөөлөл байгаа нь төслийн үйл ажиллагаа (барилга байгууламж, тээвэрлэлт, агуулах ашиглалт зэрэг) нь байгаль орчинд шууд нөлөөлөх давамгайл шинжтэйг илтгэнэ. Шууд нөлөөлөлд хөрсний эвдрэл, агаарын бохирдол, дуу чимээ, ургамлын бүтцийн өөрчлөлт зэрэг орж байна.

Хугацааны хувьд богино хугацааны нөлөөлөл 4, харин урт хугацааны нөлөөлөл 23 байгаа нь төслийн үйл ажиллагааны нөлөө нь ихэвчлэн удаан хугацаанд үргэлжлэх, тогтвортой шинжтэй байгааг харуулж байна. Ялангуяа агаарын бохирдол, хөрсний доройтол, усны чанарт үзүүлэх нөлөөлөл нь урт хугацаанд үргэлжлэх хандлагатай байна.

Нөлөөллийн чиглэлийн хувьд буцаж нөлөөлөх (сэргээгдэх боломжтой) нөлөөлөл 14, харин буцалтгүй нөлөөлөл 5 байна. Энэ нь ихэнх сөрөг нөлөөллийг зохих менежмент, нөхөн сэргээлтийн арга хэмжээгээр бууруулах боломжтой боловч зарим нөлөөлөл (жишээлбэл, газрын гадаргын өөрчлөлт, геологийн тогтцын өөрчлөлт зэрэг) нь бүрэн сэргээгдэх боломжгүйг илэрхийлж байна.

Мөн өөрөө зохицуулагдах нөлөөлөл 5 байгаа нь байгалийн нөхөн сэргэх чадвараар тодорхой хэмжээнд саармагжих боломжтой нөлөөллүүд байгааг харуулж байна.

Нөлөөллийн эрчмийн хувьд бага эрчимтэй нөлөөлөл 21, дунд эрчимтэй нөлөөлөл 6, харин хүчтэй нөлөөлөл бүртгэгдээгүй байна. Энэ нь төслийн нөлөөлөл ихэвчлэн бага болон дунд түвшинд илрэх бөгөөд зохистой менежмент хэрэгжүүлснээр байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хязгаарлах боломжтойг харуулж байна.

Иймд тус төслийн хүрээнд үүсэх сөрөг нөлөөлөл нь тоон хувьд ихэвчлэн шууд, урт хугацааны боловч бага эрчимтэй шинжтэй байгаа бөгөөд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үр дүнтэй хэрэгжүүлснээр нөлөөллийг бууруулах, зарим тохиолдолд бүрэн арилгах боломжтой гэж дүгнэж байна. Харин буцалтгүй шинжтэй нөлөөлөлд онцгой анхаарал хандуулж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тусгах шаардлагатай.

3 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Зорилго, зорилт: МАК Цемент ХХК-ийн “Барилгын материал борлуулалтын төв” төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг тус төслийн 2026 онд батлагдсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний (БОННУ) тайланг үндэслэн, Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд болон Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын шаардлагын дагуу боловсруулав. Энэхүү төлөвлөгөөний зорилго нь БОННУ-ний тайланд тусгагдсан байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомж, стандарт, журмын хэрэгжилтийг хангахад оршино.

Баримтлах зарчим: Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11 сарын 1-ний дотор Аймгийн байгаль орчны газарт 3-аас доошгүй хувь хэвлэмэл хувь хувь болон цахим хэлбэрээр хүргүүлнэ. Мөн 12 дугаар сарын 31-нд багтаан дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг Аймгийн байгаль орчны газарт батлуулах үүрэгтэй.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд (Төрийн мэдээлэл, 2012 оны 22 дугаар) аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны төлөв байдлын үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан.

Хуулийн дээрх шаардлагын дагуу төслийн үйл ажиллагаанаас тухайн нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулав.

3.1 БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДЛЫН ХУРААНГУЙ

БОМТ-г хэрэгжүүлэх 2026 оны дундаж зардлыг **16,128,600 ₮** буюу арван зургаан сая нэг зуун хорин найман мянга зургаан төгрөг байхаар тооцлоо. Төслийн БОМТ хэрэгжүүлэх 2026 оны зардлуудын хураангуйг доор харуулав.

Хүснэгт 3-1 БОМТ-г хэрэгжүүлэх зардал, 2026 он

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө		Нийт зардал, төг
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1,400,000 ₮
		Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	7,038,600 ₮
		Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	3,000,000 ₮
		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	3,350,000 ₮
		Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	500,000 ₮
2	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	740,000 ₮
3	Талуудад БОМТ-ийн тайланг тайлагнах, хэлэлцүүлэх		100,000 ₮
Нийт зардал			16,128,600 ₮

3.1.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаанаас гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх орчноор буюу агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөрс болон ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийг бууруулах, усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, амьтны аймагт үзүүлж болзошгүй нөлөөллийг бууруулах арилгах зэрэг чиглэлүүдээр бүлэглэн авч үзсэнийг Хүснэгт 6-1-т бүрэн эхээр харуулав. Төсөл хэрэгжүүлэгч энэхүү БОХТ-г бүрэн хэрэгжүүлсэн нөхцөлд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, тэдгээрийг бууруулах, арилгах бүрэн боломжтой.

Хүснэгт 3-2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
Агаарын чанар									
1	Төслийн өдөр тутмын үйл ажиллагаанд задгай болон шуудайтай цементийг хадгалах, ачиж буулгах үйл явцын явцад агаарт бохирдуулагч бодис ялгарах	Ууттай цементийн агуулах болон ачиж, буулгах талбай, тавцанг цэвэрлэх	Төслийн талбай	удаа	Зардалгүй	-	Зардалгүй	Тогтмол	MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага MNS 4990:2023 ХАБЭА. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага
2	Дотоод орчны агаарын чанар стандарт хэмжээг давах	Агааржуулалтын ажиллагаа хэвийн байгаа эсэхэд урьдчилсан шалгалт үзлэг, тогтмол хийх	Барилга байгууламж, оффис	удаа	Зардалгүй	1	-	4-р улиралд	MNS 6063:2010 Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх

3	Зам дээрх тээврийн хөдөлгөөнөөс агаарт тоосжилт үүсэх	Бараа материал материал тээвэрлэх ирэх тээврийн хэрэгслийг эзэмшлийн талбай руу тогтсон маршрутаар зорчуулах, тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Замууд	ширхэг	30,000	20	600,000	Үйл ажиллагаа ны явцад	бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
Усан орчин									
1	Усны зохисгүй хэрэглээнээс үүдэлтэй газрын доорх усны нөөц хомсдох	Усны ашиглалтын хэмжээг тогтмол бүртгэж, хяналт тавьж ажиллах	Ашиглалтын эх үүсвэр бүрд	удаа	Зардалгүй	12	Зардалгүй	Сард 1 удаа	Усны тухай хууль , MNS 4586-1998 , “Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага” MNS0899-1992 , “Унд, ахуйн зориулалттай усны төвлөрсөн хангамжийн эх булгийг сонгох журам, эрүүл ахуйн шаардлага” MNS0900-2018 , “ХБО. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ” Ус ашигласны төлбөр (Засгийн газрын 2005 оны 7-р тогтоол)
2		Бохир ус татан зайлуулах	Бохирын худаг	удаа	100,000	4	400,000	Шаардлага тай үед	
3		Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт	Үйл ажиллагааны хэмжээнд	удаа	Зардалгүй	1	Зардалгүй	Жилд 1 удаа	
4		Ус ашиглуулах дүгнэлт	Үйл ажиллагааны хэмжээнд	удаа	Зардалгүй	1	Зардалгүй	Жилд 1 удаа	
Хөрсөн бүрхэвч, газрын гадарга									
1	Шатах, тослох материал нефтийн бүтээгдэхүүн алдагдах, асгаралт үүссэнээр хөрсөн бүрхэвч бохирдох	ШТМ асгарах, алдагдах үед ашиглах хувийн хамгаалах хэрэгсэл, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах иж бүрдлийг ЗҮТ-д	Засвар үйлчилгээний талбайд	ш	280,000	1	280,000	Нэг удаа	MNS 5916-2008 “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт”, MNS 5914:2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрын

		байрлуулсныг шаардлагатай тохиолдолд шинэчлэх							нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт MNS 3297-1991 , “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм Хог хаягдлын тухай хууль MNS 5850-2019 , “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”
2	Газар хөндөлтийн бүртгэлийг тогтмол хийх	Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж аливаа газар хөндөх үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө газар хөндөх зөвшөөрөл авах, бүртгэх хяналт тавих, ГМС-д бүртгэл мэдээллийг хадгалах зураглах	Эзэмшлийн талбайн хэмжээнд	тогтмол	Зардалгүй	тогтмол	Зардалгүй	Газар хөндөх бүрд	
3	Орчны цэвэрлэгээг тогтмол хийх	Төслийн талбайн орчны цэвэрлэгээг тогтмол хийх	Эзэмшлийн талбайн хэмжээнд	тогтмол	Зардалгүй	тогтмол	Зардалгүй	тогтмол	
Ургамлан нөмрөг, амьтны аймаг									
1	Төслийн талбайд амьтан орж ирэх, эндэх	Нийт ажилчдад хууль бүс ан, бүс нутгийн ан амьтны зүйл бүрдлийн талаарх мэдээллийг постер болгон түгээх	Эзэмшлийн талбайн хэмжээнд	-	120,000	-	120,000	Жилд 1 удаа	Амьтны тухай хууль, Ургамлын тухай хууль
		Эзэмшлийн талбай болон объектууд түүний ойр орчимд зэрлэг амьтдын зүйл		удаа	Зардалгүй	4	Зардалгүй	Улирал 1 удаа	
2	Хог хаягдлыг ил задгай хаясны улмаас хөрс, ургамал бохирдох үүнийг мал амьтан идэж хордох	Хог хаягдлын цэг, түүхий эд буулгах талбайг тогтмол цэвэрлэгээ хийлгэх		удаа	Хог хаягдлын менежментийн зардалд тусгав			Улирал 1 удаа	
Нийт		1,400,000 ₮ (нэг сая дөрвөн зуун мянган төгрөг)							

3.1.2 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний ажлын зардалд 7,038,600 ₮ буюу долоон сая гучин найман мянга зургаан зуун төгрөг зарцуулах тооцоо гарсан болно.

Хүснэгт 3-3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
Төслийн талбайн орчны тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлж, тоосжилтыг бууруулах, ажлын орчны чанарыг сайжруулах, экологийн тогтвортой байдлыг дэмжих	Эзэмшлийн талбайг зүлэгжүүлэх	Эзэмшлийн талбай	м2	1000	4500	4,500,000	Хаврын тариалалт	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, Ургамал хамгааллын тухай хууль болон бусад хууль, холбогдох дүрэм журам, стандарт
	Эзэмшлийн талбайн ногоон байгууламжийн арчилгаа хийх	Эзэмшлийн талбайд	удаа	30	Үйл ажиллагааны зардлаас	Дулааны улиралд	Дулааны улиралд	
	Тэрбум модны хүрээнд эзэмшлийн талбайд мод тарих /140ш агч, 10 нарс/	Эзэмшлийн талбайд	ш	150	16,924	2,538,600	Хавар, Намрын тарилт	
Нийт	7,038,600 ₮ (долоон сая гучин найман мянга зургаан зуун төгрөг)							

3.1.3 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төсөл хэрэгжих талбай орчимд хийгдсэн судалгаагаар ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор бүртгэгдээгүй. Цаашид үйл ажиллагааны явцад соёлын өв олдсон тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30.4-т заасны дагуу олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор сум, дүүргийн бүртгэл мэдээллийн санд заавал бүртгүүлнэ.

3.1.4 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 3-4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн зардал төг	Тоо хэмжээ	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	2	3	5	6	7	8	9
Байгалийн гамшигт үзэгдлүүд	Эрх бүхий байгууллагаар Гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийлгэнэ. ¹	Эзэмшлийн талбайд	2,500,000	1	2,500,000	Хуулийн хугацаанд	Засгийн газрын 2018 оны 67 дугаар тогтоолын хавсралт Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам Гамшгаас хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/
Үер	Хаврын шар ус, хур бороо элбэгтэй үед үерт автах аас сэргийлж үс зайлуулах сүваг хоолой, даланг технологийн дагуу мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Эзэмшлийн талбайд	Үйл ажиллагааны зардалд	1	Үйл ажиллагааны зардалд	4,5,6-р саруудад	MNS 4968:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага. MNS 4969:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуйн сургалтын зохион байгуулалт үндсэн дүрэм MNS 5390:2004 Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага. MNS ISO 13688:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуй. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага.
Гал түймэр	Галын аюулын талаар анхааруулга самбарыг шинээр барьж буй объект бүрд онцлогийг нь тусган тавих. Гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдэл, галын сарайг бэлэн байлгах.	Эзэмшлийн талбайд	50,000	10	500,000	8-р сард	
Үйл ажиллагааны осол гэмтэл	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах	Нийт ажилчид	Үйл ажиллагааны зардалд	Ажилчдын тоогоор	Үйл ажиллагааны зардалд	Ажилчин ажилд орох бүрд	
	Бүх ажилчдад ажил эхлэхийн өмнө хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, хамрагдаагүй ажилчдыг тухайн өдөрт ажиллахыг хориглох	Нийт ажилчид	Зардалгүй	350	Зардалгүй	Өдөр бүр	

	Анхан түслэмжийн багаж, эмийн санг шинэ ажилчдын байранд байрлуулах	Эзэмшлийн талбайд	Үйл ажиллагааны зардалд	2	Үйл ажиллагааны зардалд	7-р сард	MNS 4970:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Өргөх, зөөх ачааны массын дээд хэмжээ.
Техник, Тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэл гарах	Тоног төхөөрөмжийг тогтмол шалгаж засвар үйлчилгээг тогтмол хийх, бүртгэл хөтлөх.	Нийт техник хэрэгсэл	Үйл ажиллагааны зардалд	4	Үйл ажиллагааны зардалд	Улиралд нэг удаа	MNS 4992:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага. Галын аюулгүй байдлын тухай хуулийн 16.1.7 MNS 5566:2020 Галын аюулаас хамгаалах. Аж ахуйн нэгж, байгууллага барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм.
НИЙТ ЗАРДАЛ					3,000,000 ₮ (гурван сая төгрөг)		

3.1.5 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Үйл ажиллагаанаасаа гарч буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах зарчмыг баримтлан ажиллана.

Хог хаягдлын сөрөг нөлөөлөл болон түүний хэмжээг бууруулахад 2026 онд 3,350,000 ₮ буюу гурван сая гурван зуун тавин мянган төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.

Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2017/ болон Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/443 дугаар тушаалаар батлагдсан “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”-д тус тус зааснаар төсөл хэрэгжүүлэгч МАК цемент ХХК нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- ❖ Хог хаягдлаа эрх бүхий байгууллагаар “Хог ачиж, тээвэрлүүлэх гэрээ”-ний дагуу ангиллын төрөл тус бүрээр нэгдсэн хогийн цэг рүү ачуулах
- ❖ Үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах эрх бүхий байгууллагад гэрээ байгуулан шилжүүлэх, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын дотоод болон гадна орчны цэвэрлэгээг хариуцах үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байх

- ❖ Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлөх
- ❖ Байгууллагын ажилтнуудад хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях талаар сургалт зохион байгуулж, зохих мэдлэгийг эзэмшүүлэх, дадал зуршлыг хэвшүүлэх;
- ❖ Орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газар, зам талбайн хог хаягдал, шарилж, лууль зэрэг ургамал, цас мөсийг тогтмол цэвэрлэх;
- ❖ Бүх нийтийн их цэвэрлэгээнд ажилтан, албан хаагчдыг хамруулах, холбогдох зардлыг гаргаж цэвэрлэгээний багаж хэрэгслээр хангах;
- ❖ Бүх нийтийн их цэвэрлэгээний өдрүүдэд орон нутгийн захиргаанаас зураглалаар хариуцуулсан нийтийн эдэлбэр газар, гудамж, зам, талбайн хог хаягдлыг цэвэрлэж, холбогдох байгууллагад хүлээлгэж өгөх
- ❖ Энгийн хог хаягдлыг хамгийн багадаа 3 төрлөөр буюу 1. Дахин боловсруулах боломжтой 2. Дахин боловсруулах боломжгүй 3. Хүнсний органик хог хаягдал гэж төрөлжүүлэн эх үүсвэр дээр ангилан ялгах;
- ❖ Картон цааснаас бусад төрлийн ангилсан хаягдлыг зориулалтын уутанд хийж, уутны амыг боож битүүмжлэн шаардлага хангасан хогийн сав, бункерт байршуулан хадгалах ба хог ачиж цуглуулах хуваарийн дагуу ангиллын төрөл тус бүрээр хог тээврийн авто машинд ачуулах;
- ❖ Энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах төрлийг хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэлтэй уялдуулан төсөл хэрэгжүүлэгч өөрийн санаачилгаар нэмэгдүүлэх
- ❖ 0,75 м³-с дээш эзлэхүүнтэй овор хэмжээ их энгийн болон барилгын хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3-д заасны дагуу нэмэлт үйлчилгээний хөлс төлж эрх бүхий мэргэжлийн байгууллагаар тээвэрлүүлэх

Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт “Барилгын материал борлуулалтын төв” байгуулах төслийн 2026 оны байгаль орчны төлөв менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 3-5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1.	Ахуйн	Хог хаягдлын нэгдсэн сав байршуулах, тогтмол ариутгал, цэвэрлэгээ хийх	Хог хаягдал хадгалах түр цэг	ширхэг	2,550,000	1	2,550,000	2026 онд тогтмол сард нэг удаа	Хог хаягдлын тухай хууль; Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/349 дугаар тушаалын хавсралт. Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл; MNS 5344 : 2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага; Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт. Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам
		Хог хаягдлыг ангилан ялгаж, тохижилт үйлчилгээний газартай гэрээг сунгах, сар бүр тогтмол зөөвөрлүүлэх	Төслийн талбай	удаа	15,000	12	180,000	2026 онд тогтмол сард 1 удаа	
		Ажилчдад хог хаягдлаа бууруулах, ангилан ялгах талаарх мэдээллийг самбарт байршуулах	Төслийн ажилчдад	ширхэг	120,000	1	120,000	2026 онд 1 удаа	
2.	Үйлдвэрийн	Цэвэрлэх байгууламжийн хаягдал үс болон лагыг тогтмол холбогдох байгууллагад нийлүүлэх	Үйлдвэрийн талбай	удаа	Үйл ажиллагааны зардал	тогтмол	Үйл ажиллагааны зардал	Тогтмол	
		Түүхий эдийг зориулалтын бус талбайд буулгахыг хориглох, буулгасан талбайд тогтмол цэвэрлэх	Хог хаягдал хадгалах түр цэг	удаа	-	-	Үйл ажиллагааны зардал	Түүхий эдийн хаягдал үүсэх бүрт	
3	Аюултай	Үйл ажиллагаанаас гарч буй химийн бодисын сав баглаа боодлыг журмын дагуу түр хадгалан, тусгай зөвшөөрөл бүхий байгууллагад өгөх	Үйлдвэрийн талбай	Удаа	250,000	2	500,000	2026 онд Хуулийн хугацаанд	
	Нийт		3,350,000 ₮ (гурван сая гурван зуун тавин мянган төгрөг)						

3.1.6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (БОХШХ) нь байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл болон үйл ажиллагааны явцад гарч болзошгүй эрсдэлийн үед байгаль орчинд бий болох бохирдол, доройтлыг тодорхойлох зорилготой заавал хэрэгжүүлэх баримт бичиг юм. Хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн нөлөөлөлд өртөх орчин тус бүрийг хянах гол үзүүлэлтүүд, хяналт шинжилгээ хийх давтамж, шинжлэх арга, дээж авах, хадгалах, тээвэрлэх шинжлэхэд баримтлах стандарт шаардлага зэргийг багтаасан болно. БОХШХ-ийг хэрэгжүүлэхдээ энд заагдсан бохирдуулах эх үүсвэрүүдийг хянах Монгол Улсын хууль тогтоомж, стандартчилагдсан арга зүйн хязгааруудыг баримтлах шаардлагатай ба дээрх эрх зүйн актууд, стандартууд шинэчлэгдвэл түүний шинэчилсэн хувилбарыг мөрдөж ажиллах ёстой. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж үр дүнг нь доорх асуудлуудыг тодорхойлох, үнэлэхэд ашиглана. Үүнд:

✓ Анх таамагласан сөрөг нөлөөллүүдийн хэмжээ, үр дагавраас бодит сөрөг нөлөөлөл, түүний үр дагавар хир зөрж байгааг,

✓ Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт болон холбогдох эрх зүйн баримт бичиг, стандарт, дүрэм журамтай нийцэж байгаа эсэхийг,

✓ Нөлөөллүүдийн эрчим, буурах эсвэл ихсэж байгааг,

✓ Төслийн БОХТ-ний нийт үр ашгийг үнэлэх зэрэг орно.

Хүснэгт 3-6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн өртөг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт ба арга, аргачлал
1	2	3	4	5	6	7	8
Агаарын чанар							
Ялгарах бохирдуулагчид: SO2, NO2	Төслийн талбайгаас	Жилд 1 удаа	1	170,000	170,000	-	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага /MNS 4585 : 2016/ MNS ISO 4221: 2002, Агаарын чанар. Орчны агаарын хүхрийн давхар ислийн агуулгыг тодорхойлох
Тоосны хэмжилт: PM10, PM2.5	Төслийн талбайгаас	Жилд 1 удаа	1	50,000	50,000	-	
Хөрсөн бүрхэвч							
Хүнд металлын (Cr, Cu, Pb, Ni, Zn) агууламжийг тодорхойлох	Төслийн талбайгаас 3 дээж	Жилд 1 удаа	1	32,500	97,500	-	MNS 3298-1991 Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд;

Дархан-Уул аймгийн Дархан сумын нутагт “Барилгын материал борлуулалтын төв” байгуулах төслийн 2026 оны байгаль орчны төлөв менежментийн төлөвлөгөө

Шимт хөрсний хими, физик шинж чанар	Төслийн талбайгаас 3 дээж	Жилд 1 удаа	1	35,000	105,000		MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ;
Усны чанар							
Усны хими болон физикийн үзүүлэлт, pH, Эрдэсжилт, ЦДЧ, химийн үндсэн анион ба катион, умбуур бодис, хатуулаг, хүнд металлын агууламж	Унд ахуйн уснаас	Жилд 1 удаа	1	44,500	44,500	-	Байгаль орчин. Хүний эрүүл мэндийн хамгаалалт. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлагууд болон чанарын хяналт MNS 900:2018
Хүнд металлын агууламж	Технологийн ус	Жилд 1 удаа	1	56,000	56,000		
Хаягдал усны агууламж	Бохирын цооног	Жилд 2 удаа	1	108,500	217,000	-	Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015
Орчны хяналт шинжилгээ хийхэд зарцуулагдах урьдчилсан байдлаар тооцсон зардал						740,000 ₮ (долоон зуун дөчин мянган төгрөг)	

3.1.7 Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Төслийн 2026 оны явцад удирдлага зохион байгуулалтын хүрээнд 500,000 ₮ буюу таван зуун мянган төгрөг зарцуулах төлөвлөгөөг гаргалаа.

Хүснэгт 3-7. Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв , мян.төг	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан
			2026 он			
			1-4 Сар	5-8 Сар	9-12 Сар	
1	Байгаль орчны менежментийн тогтолцоог сайжруулах талаар мэдлэг, ойлголтыг ажилчдад өгч байх.	Үйл ажиллагааны зардалд тусгах			9-р сар	Удирдлага, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн
2	Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэлийн дагуу хог хаягдлын төрөл, кодыг тогтоон ялгаж бүртгэл хөтлөх	Үйл ажиллагааны зардалд тусгах	Жилийн турш			Удирдлага, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн
3	Байгаль орчныг хамгаалах, осол, гал түймэр, гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шүүрхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалтыг зохион байгуулах	Үйл ажиллагааны зардалд тусгах		7-р сард		Удирдлага, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн
4	БО-ны мэдлэг нэмэх, стандартыг мөрдөх, зүй зохистой ашиглалтыг нэмэгдүүлэх хүрээнд таних мэдэхүйн болон анхааруулга, санамж тэмдгүүд байршуулах	500.0			11-р сар	Удирдлага, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн
5	Төслийн талбайд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, техник ашиглалтын талаарх мэдээлэл бүхий самбар, тэмдэг байршуулах, мэдээллийг цаг тухай бүрд нь шинэчилж байх	Үйл ажиллагааны зардалд тусгах	Жилийн турш			Удирдлага, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн
6	Ус, хог тээврийн гэрээг холбогдох байгууллагуудтай сунгах, төлбөрийг тогтмол төлөх	Үйл ажиллагааны зардалд тусгах	Ажил гүйцэтгэсэн сар бүрийн эцэст			Удирдлага, байгаль орчны мэргэжилтэн
7	Ажилчдын эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Үйл ажиллагааны зардалд тусгах				Удирдлага, байгаль орчны мэргэжилтэн
	Нийт зардал	500,000 ₮ (таван зуун мянган төгрөг)				

3.1.8 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө
Жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар БОУАӨЯ-д тайлан хүргүүлэх бөгөөд нийт 100,000 ₮ төсөвлөлөө.

Хүснэгт 3-8. БОМТ-ний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Тайлагнах зардал, сая төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7
Төрийн захиргааны төв байгууллага /БОУАӨЯ/	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны БОМТ-ний төсөлтэй хамтатган ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тухай	Жил бүрийн 12-р сарын 10-ны дотор	Үйл ажиллагааны зардалд тусгах	Байгаль орчны мэргэжилтэн	БОУАӨЯ
Аймгийн БОГ	БОМТ тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, ажлын хэсгийн хурлаар оруулж танилцуулах.		Жил бүрийн 11-р сарын 10-ны дотор			Аймгийн БОГ-т
Төсөл хэрэгжих нутгийн иргэд	БОМТ-ний хэрэгжилтийн тайланг 13-р багийн иргэд, нөлөөллийн бүсийн оршин суугчид		Жил бүрийн 11-р сарын 10-ны дотор			ИНХ

ХАВСРАЛТ

№	Хавсралтын жагсаалт	Хуудасны тоо
1	Улсын бүртгэлийн гэрчилгээ	2
2	Тусгай зөвшөөрөл	3
3	Газрын гэрчилгээ	2
4	Кадастр	5
5	Батлагдсан зураг төсөл	2
6	Батлагдсан БОННУ тайлангийн нүүр	1
7	Ерөнхий үнэлгээний дүгнэлт	7
8	Хог тээврийн гэрээ	2
9	Бохир соруулах гэрээ	4